



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/91

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, төрийн үйлчилгээг ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд түргэн шуурхай хүргэх үйлсэд хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж буй хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 60000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 60000 төгрөг/жаран мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 15-ны өдрийн
А/91 дүгээр захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Мөнгөн дүн
1	Д.Эрдэнэдорж	Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн	30000
2	Б.Ганбат	Хүнс, хөдөө аж ахуйн газрын сахиул	30000
Дүн			60000

-oOo-